



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 4/609

Хэрлэн сум

Хүүхдийн хоолны зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.5.1, Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 207 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүүхдийн хоолны зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн

дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн

дарга:

Боловсролын газрын дарга

Гишүүд:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Боловсролын газрын сургалтын орчин, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан ахлах арга зүйч

Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний стандартын хяналтын улсын ахлах байцаагч

Эрүүл мэндийн газрын хүнсний эрүүл ахуйн байцаагч

Хан Хэнтий сургуулийн захирал


Хэрлэн 1 дүгээр сургуулийн хоол зүйч

Аймгийн тогоочдын холбооны тэргүүн

2. Зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцон, үр дүнг танилцуулахыг зөвлөлийн дарга (Б. Өнөрцолмон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



D:\My Documents\Захирамж-2024

231011721